

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ, СОЁЛ

**ФЕОДАЛЫН ХЯТАД УЛС
(III зуун--1911 он)****Н. Ишжамц**

ШУА-ийн сурвалжлагч гишүүн

Хятад улс бол өөрийн түүхэн хөгжлийн явцад эзэн, боолын нийгмээс феодализмд дэвшин орсон орны нэг юм. Тийм учраас феодализм анх үүсэн бүрэлдэж байсан феодалын түрүү үеийн Хятад орон нь хүй нэгдлийн байгууллаас эзэн, боолын нийгмийг алгасан феодализмд орсон зарим улс орныг бодвол харьцангуй давуу хөгжилтэй байжээ. Феодалын Хятадын нийгэм нь тус орны хөгжлийн өмнөх үеийн уламжлал дээр, тухайлбал эзэн, боолын нийгмээс өвлөгдөн үлдсэн улс төр, эдийн засаг, соёлын үндсэн дээр тулгуурлан хөгжсөн байна. Феодалын Хятад улс нь хөрш зэргэлдээх улс орон, алс холын зарим улсын эдийн засаг, соёлын ололтоос авч хэрэглэн, мөн өөрөө тэдэнд зарим талын нөлөө үзүүлж байжээ. Хятадын феодалын төрүүдийн гадаад харилцаанд бусад оронтой дайн дажин болох, худалдаа хийх, шашин соёлоор нэвтрэлцэх зэрэг янз бүрийн асуудал гарч байв.

Хятад орны туулж өнгөрсөн феодализм нь мөн чанар, агуулгын хувьд бүх гол зүйлээрээ бусад улс орныхтой нийтлэг шинжтэй байсныг тэмдэглэвэл зохино. Бусад улс орны нэгэн адилаар Хятадын феодализм нь феодалын газар өмчлөл дээр суурилан тогтож, түүний үндсэн дээр хамжлагат ёс үүсч орон даяар ноёрхоод эдийн засгийн биш албадлага өргөн дэлгэрсэн байв. Тухайн үеийн хятадын нийгэм нь газрын эзэн феодалын ноёлогч анги, дарлагдан мөлжигдсэн тариачдын анги болж хуваагдаад ангийн тэмцэл улам бүр хурцадсаар байв. Тариачдын бослого үе үе хүчтэй өрнөж янз бүрийн угсааны феодалын төрийг мөхөөх боловч түүний оронд өөр угсааны феодалын төр дахин гарч ноёлдог байв.

Хятадын феодализм нь дорнодахины олонхи улс орны нэгэн адилаар зарим өвөрмөц онцлогтой байсан тал бий. Тухайлбал Хятадад феодалын газар эзэмшил ихэд дэлгэрсэн байсан боловч бүх газрын дээд өмчтөн эзэн нь феодалын төр буюу түүний тэргүүн, эзэн хаан байсан юм. Нөгөөтээгүүр, феодалын төр нь гол төлөв ихэд төвлөрсөн байдал бүхий, хязгааргүй эрхтэй, эзэрхэг засаг байв. Эзэн хааныг «тэнгэрийн хүвгүүн» хэмээн өргөмжлөвч бурхан шүтээн гэж үздэггүй байв. «Дээд тэнгэр» хэмээх бурхан байдаг гэж ярихч шашин шүтлэгийг асар эрхэмлэж байсангүй. Феодалын хятадын төрийн үзэл суртлын гол зэвсэг нь күнзийн сургаал байсан боловч тэр нь жинхэнэ шашин биш байв. Шашны шинжтэй болсон даосын сургаал, мөн бүддийн шашин чухал үүрэг гүйцэтгэж байсан ч гэсэн ноё-

лох байр суурь бараг эзэлдэггүй байлаа. Шашин хааяа зонхилсон цагт шүтлэг тийм тууштай биш, бишрэл баахан хуудам байдаг байжээ.¹ Хятадын уламжлалт ёсонд «хойт насны жаргалаас» энэ ертөнцийн амьдрал илүү эрхэмлэгдсээр байв. Энэ бүхэн нь Хятадын түүх, шинж чанар ба онцлог нийгмийн ахуй, хятад хүний сэтгэхүйн шинж чанар ба онцлогтой холбогдол бүхий ажээ.

Эртний үе дэхийн нэгэн адилаар дундад зууны феодалын Хятад улсын дэвсгэр нутаг нь Хятадын Цагаан хэрмээс урагших дорнод Азийн нэлээд өргөн дэлгэр нутгийг эзэлж байв. Цагаан хэрмийн дотоод дахь газар нутгийн гол хэсэг нь Хятад орон, хятад угсаатны жинхэнэ өөрийн ууган нутаг юм. Эрт, дундад зууны Хятад улс, хятад угсаатан чухам тэр нутгийг өөрийн эх орон гэж эзэмшин байв. Хятадын ард түмэн болон эрт, дундад үеийн хятадын угсааны төрүүд нь өөрийн улсын умард хил болон Цагаан хэрмийн гаднах Төв Азийн хүннү, сяньби, муюн, тоба, зүрчид, тангад, төвд зэрэг угсааны улс аймгуудын болон мөн өмнөд, дорнод хилийн чанадах Бирма, Индонез, Вьетнам, Лаос, Кампучи, Солонгос, Япон зэрэг эргэн тойрны улс аймгийн нутгийг хятадын нутаг биш, харь улс аймгийн гадаад орнууд гэж зүй ёсоор үздэг байв. Үнэхээр монгол, түрэг, манж, төвд зэрэг Төв Азийн нүүдэлчин улс түмнүүд, түүнчлэн Вьетнам, Солонгос зэрэг Зүүн Өмнөд ба Дорнод Азийн зах хязгаар, Номхон далайн баруун эргийн бүс нутгийн улс аймгууд нь цөм тус тусдаа Хятадаас өөр гарал угсаа, ондоо хэл соёл, зан заншил бүхий биеэ даасан улс түмнүүд байв. Феодалын хятадын төрүүд нь өөрийн улсыг «ертөнцийн төв» мэт үзэж, тэдгээр улс аймгуудыг зөвхөн гадаад «зах хязгаар» хэмээн жанжлах бодлого явуулж байсан боловч орчин үеийн Хятадын их гүрний жанжлах үзэлтнүүдийн адил тэдгээр улс орныг хэзээнээсээ нааш Хятадын «салшгүй хэсэг» байсан гэж үзэж байгаагүй юм. Тийм учир дундад зууны Хятадыг Төв Ази, алс дорнодын олон аймаг угсаатныг өөртөө багтаан нэгтгэсэн «олон үндэстний улс» байв хэмээн жанжлах бодлоготнуудын захиас даалгавраар зарим хятад түүхчдийн бичиж байгаа нь түүхэн үнэнд үл нийцэх ажээ.

Хятадын түүх бол бусад улс орны түүх болон алив бүх үзэгдлийн нэгэн адил улиран хувьсч, шат үе ахин хөгжсөөр ирсэн диалектик хөдөлгөөнт материаллаг үйл явц хэмээн үзвэл зохино. Бидний бодоход марксч-ленинч онол-аргазүйн үүднээс өнөөгийн БНХАУ-ын түүхийг судлахдаа түүний хил хязгаар дотрох олон үндэстэн угсаатны түүхийг зохих ёсоор зөв харж үзэх нь зүйн хэрэг боловч тэр бүхнийг цөмийг анхнаасаа өнөөгийнх шиг тус орны бүрэлдүүн хэсэг байсаар ирсэн мэт дүрслэх явдал үнэн байдалд ноцтой харшлана. Олон үндэстний бүрэлдэхүүн бүхий өнөөгийн Хятад улсыг нэгдмэл нэгэн хятад үндэстэн («Чжунхуа миньцзү») хэмээн үзэж үл болохын нэгэн адил дан ганц буюу гол төлөв хятад угсаатныг захиран байсан эрт, дундад зууны Хятад улсыг «олон үндэстний» улс байв хэмээн үзэх үндэс үгүй билээ. Хятад улс бол эрт, дундад зууны үед дан ганц буюу ихэвчлэн гагцхүү Хятад угсаатны ноёлох ангиудын төр байгаад шинэ үед олон үндэстний улс болох үндэс суурь нь тавигдаж, шинэ үеийн сүүлч, шинэхэн үеийн эхээр олон үндэстний улс болж хөгжсөн байна. Жанжлах үзэл, бодлогын үүднээс метафизик, эклектик, софизмын арга хэрэглэж түүнийг эс гуйвуулан жинхэнэ материалист диалектик, түүхэн мате-

¹ Л.В. Васильев. История религий Востока. М., 1983, с. 273. 280—282.

риализмын үүднээс үзвэл Хятадын түүхэн хөгжлийн зүй тогтол, үнэн байдал ийм маягаар зөв зүйтэй тусгагдан гарч, пролетарийн интернационализм, улс түмний найрамдал, хамтын ажиллагаа ба энх тайвны үйл хэргийн хэрэгцээ шаардлагад харшлахгүй, Хятадын ард түмний өөрийнх нь амьдрал, хөгжлийн ашиг сонирхолд нийцэх мэт санагдана.

Хэрэв Итали зэрэг баруун Европын зарим улс орон V зууны үеэс эхлэн феодализмд орж байсан бол Хятад орон III зууны үед феодалын улс болох зам дээр нэгэнт гарч ирсэн байна. Эртний Хятадын Хан улсыг мөхсөний дараа III зууны үед Хятад орон нэгдмэл байдлаа алдаж, биеэ даасан гурван улс болж хуваагдсан юм. Тухайлбал 220 оны үест Умард хятадад Цао Цао хэмээх феодалжигч сурвалжтан ноёны угсааны хаадын толгойлсон Вэй улс байгуулагдаж Лоян хотод нийслэлсэн байна. 221 онд өрнөд хятадын Чэндү хотод нийслэлсэн Шү улс, 229 онд Зүүн өмнөд Хятадын Нанжин хотод төвлөсөн Ү улс тус тус бий болжээ.

265 онд Вэй улсын цэргийн жанжин Сыма Янь өөрийн улсын төрийн эрхийг гартаа авч, бусад хоёр улсыг эзлэн Хятад орны нэгдлийг сэргээн Чанань хотод нийслэл бүхий Цзинь улсыг байгуулсан байна. Тэр үеэс эхлэн умард Хятадын төрийн хэрэгт монгол, түрэг угсааны өмнөд хүннү, монгол угсааны сяньби, муюн, тоба нар болон төвд, тангад угсааны Цян зэрэг Төв Азийн нүүдэлчин улс аймгууд идэвхтэй оролцох болж байв. I зууны эцсээр Хүннү гүрнийг мөхсөний дараа одоогийн Өвөр Монголын Ордос нутагт оршин амьдарч байсан Өмнөд Хүннүгийн таван аймаг өөр хоорондоо нийлэн нэгдэж, 304 онд хүннү, хятадын хилийн районд өөрийн төр улсыг тэрлэн байгуулж, Цзинь улсад довтлон 316 онд нийслэл Чананийг эзлэн авчээ. Цзинь улсын хаад ноёд Хөх мөрний өмнө зугтан гарч, тэнд төвлөн 420 он хүртэл Өмнөд Хятадад төр улсаа тогтоож байв. 351 онд Сяньби угсааны муюн нар Умард Хятад дахь Өмнөд Хүннүгийн төрийг мөхөөж, өөрийн ноёрхлыг тогтоосон боловч 370 онд Цянь аймгуудад цохигдож, тэдэнд төр улсаа автсан байна. 386 онд Өмнөд Монголын Сяньби, Муюн нарын угсааны тоба аймгууд нэгдэж Төв Азийн нүүдэлчдийн бас нэгэн төр улсыг байгуулаад хойт, баруун хойт Хятадыг эзлэн захирсан нь түүхэнд Умард Вэй улс гэж алдаршжээ. Умард Вэй улс нь Пинчэн, Лоян хотуудад нийслэлж байсан бөгөөд тухайн үе хүртэл Хойт Хятадад ноёрхож байсан нүүдэлчдийн төрүүдээс хамгийн хүчирхэг бөгөөд нэлээд өндөр хөгжил бүхий соёлтой улс байв.²

581 онд Янь Цзянь хэмээх хятад цэргийн жанжин Умард Вэй улсад төрийн эргэлт хийж, засгийн бүх эрхийг гартаа оруулж аваад улмаар Өмнөд Хятадыг эзлэн захирч, Сүй улсыг байгуулан Хятад орны нэгдмэл байдлыг сэргээсэн байна. Сүй улс Чанань хотод төвлөн нийслэлсэн дундад зууны Хятадын анхны томоохон эзэнт гүрнүүдийн нэг байв. Сүй улс нь харь орнуудын эсрэг аян дайн хийж, улсын дотоодод их хэмжээний суваг шуудуу татах, барилга байгууламжийн ажил зэрэгт хөдөөгийн тариачдыг хэт зүтгүүлж, алба татварыг ширүүсгэсний улмаас VII зууны үед Хэбэй, Хэнань зэрэг мужид бослого хөдөлгөөн гарч, хүчтэй эсэргүүцэл тэмцэл өрнөсөн байна.

Тэр далимаар Сүй улсын цэргийн жанжин Ли Юань гэгч хүн өөрийн улсын хааныг огцруулж, 618 онд биеэ хаан хэмээн өргөмжлөн Чанань хотод нийслэлтэй Тан улсыг байгуулсан юм. Ялангуяа түүний

² Фань Вэньлань. Хятадын нэвтэрхий түүх. II боть, 5 дахь удаагийн хэвлэл. Бээжин, 1978, 656—658-р тал. (хятадаар)

хүвгүүн (627--619 оны үест төрийн эрхийг барьж байсан) Ли Шиминь хааны үед Хятадын Тан улс ихээхэн хүчирхэг гүрэн болж хөгжсөн байна. Тан улсын соёл, урлаг нь ч гэсэн урьдах үеүдийнхээсээ үзтэл давуу талтай байсныг түүх сударт тодорхой тэмдэглэж үлдээсэн байна.

Гурван улсын үеэс эхлээд Тан улс хүртэлх үеийн Хятадад нийгмийн үйлдвэрлэх хүчин, эдийн засаг аажмаар урагшлан хөгжиж, феодалын газар эзэмшил, хамжлагат ёсны зэрэг феодалын үйлдвэрлэлийн харилцаа, эдийн засгийн үндэс суурь үүсэн бүрэлдсэн түрүү феодализмийн хөгжлийн шат буюу феодалын түрүү үеийн хэрэг явдал өрнөж өнгөрсөн байна.

Эртний Хятадын эзэн боолын ёст Хан улс дотоодын дайн дажин, бослого хөдөлгөөнд автан мөхөх үеэр, түүнчлэн гурван улсын хоорондын дайн самуунд хот, хөдөөгийн маш олон хүн амь үрэгдэж, орон даяар эзгүйрэн хоосорч, эл хуль болоод байв. Тийм нөхцөлд гурван улсын хаад нь улсын өмч эзэмшлийн их хэмжээний газар нутгийг ноёд, түшмэд, цэргийн дарга нартаа хуваан өгч, тэдгээр газар дээр цэрэг тус бүрд өчүүхэн оногдол газар олгож тариа тариалан «түнтянь» хэмээх цэргийн тариалангуудыг байгуулсан байна. Тийм тариалангийн ургацын дийлэнх ихэнхийг улсад тушаагаад үлдсэн бага хэсгийг цэргүүд өөрсдөө авч байв. Цэргийн тариалан дээр ажиллаж цэргүүд урьдын адил боол шивэгчний байдалтай биш, харин хараат албатын байдалд орсон байв. Түүнээс гадна, урьд үеэс уламжилж ирсэн «баян хүчирхэг айл өрхүүдийн» эзэмшил газар, аж ахуй дээр нэгэн талаас урьд нь боол шивэгчин байгаад үндсэндээ чөлөөлөгдөж хараат албат бологсод, нөгөө талаас урьдын цагт хөршийн хүй нэгдлийн чөлөөт тариачид байгаад бас нэгэнт хараат албатын байдалтай бологсод тус тус ажиллаж байв. Энэ мэтээр гурван улсын үеэс эхлэн эзэн хаад, ноёд түшмэд, цэргийн дарга нар нь газрыг эзэмшин, цэрэг, тариачдыг албат хараатаа болгон, эдийн засгийн биш албадлагаар хөдөлмөрлүүлэн зүтгүүлдэг феодалжигч язгууртны байдалд орж, тариачид, цэрэг нь тэднээс хараат байдалтай албатын шинж төрхийг олж байв. Тийнхүү гурван улсын нийгэм феодалжиж эхэлсэн байна.

Феодалын үйлдвэрлэлийн харилцааны эх үүсвэр, ялангуяа тариачид амин хувийн оногдол газартай (цзюнь тянь, фэньтянь) болсон явдал тэдний ажиллах сонирхол, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлсэн байна. Энэ бүхний ачаар Цзинь, Умард Вэй, Сюй, Тан улсын үед Хятад орны үйлдвэрлэх хүчин, аж ахуйн хөгжилд цаашдын ахиц гарчээ. Тухайлбал, Умард Вэй улсын үед цай, нишингэ, хөвөн зэрэг ургамлыг шинээр тарьж хэрэглэх болсон байна. Сүй улсын үед Шар мөрөн, Хөх мөрөн хоёрыг холбосон 1000 гаруй км урт «Хятадын их суваг» хэмээх томоохон суваг шуудуу татагдаж, тарианы газр талбай гурав дахин нэмэгдсэн байна. Тан улсын үед төмөр, өнгөт металл, шавар сав, шаазан ваарын үйлдвэрлэл хөгжиж, хятадын хүрэл толь, шаазан ваар гадаадад алдаршсан байна. Аж ахуй, үйлдвэрлэлд тийм ахиц гарсан нь феодалын үйлдвэрлэлийн харилцаа ялж зонхилоход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэжээ. Тан улсын үед газрын эзэд, түшмэд нь тариачдын оногдол газрыг булаан авах, барьцаанд авах, худалдан авах зэргээр их хэмжээний хувийн өмчийн газартай болж, түүнийгээ үе улиран эзэмших болсон байна. Үе улиран эзэмших «чжуаньтянь» хэмээх тийм газрын эзэмшил нь гүйцэд бүрэлдэн тогтсон феодалын газар өмчлөлийн гол хэлбэр болсон байв. Нэгэнт Вэй улсын үеийн Хятадад 485 оны үед нийтлэгдсэн цааз хуулийн дотор тариачдын тухай

өгүүлэхдээ: «Тарианы газар хангалттай байсаар байтал зохих шалтгаангүйгээр өөр газарт шилжин суухыг үл зөвшөөрмүй» гэснээс үзвэл тариачдыг оногдол газар дээр нь бэхлэн хадаж, харьяат албат болгон хамжлагачлах явдал эхэлсэн байжээ. Тан улсын үед алба татварыг оногдол газартай хүний тоогоор бодож татдаг байсан хуучин журмыг өөрчилж, газрын эзэд, түшмэдийн эзэмшил, тариачдын оногдол газрын хэмжээгээр бодож алба татдаг болсон нь бусдын газар дээр ажиллаж амь зуудаг, өөрийн гэх оногдол газаргүй ядуу хоосон тариачдыг хүртэл алба татварт хамааруулж, хэрэг дээр нийт тариачдыг эзний газар дээр бэхлэн хадсан хэрэг байв. Тэр тухай 763 онд эзэн хааны тусгай зарлиг нийтлэгдсэн явдал бол феодалын газар эзэмшил, түүн дээрхи тариачид нь феодалын харьяат хамжлага болохыг албан ёсоор хуульчлан тогтоосон хэрэг байв. Тийнхүү Тан улсын үед Хятад оронд феодалжих үйл явц дуусч, феодалын түрүү үеийн хөгжлийн зорилт хэрэгжсэн байна.

X—XVII зууны үеийн Хятад орон бол феодализм улам улмаар гүнзгийрэн хөгжиж байсан хөгжмөл феодалын улс байсан юм. Тухайн үед феодалын газар эзэмшил, хамжлагат ёс өргөжин бэхжиж, эдийн засгийн биш албадлага нэн хүчтэй болж нарийсан, ангийн тэмцэл ихэд хурцадсан байв.

907—960 оны үест Умард Хятад нь Хожуу Лян, хожуу Чжоу гэх зэрэг феодалын таван төр болж хуваагдсан байлаа. Мөн тэр үеийн Өмнөд Хятадад Ү, Юэ, Түрүү Шү гэх мэтийн 10 феодалын улс бий болсон байв. Хятадын түүх сударт тухайн үеийг Өмнөд, Умард төрийн үе буюу таван төр, арван улсын үе гэж тэмдэглэсэн байдаг. Хятад орон тэр үед феодалын тархай бутархай байдалд автан Умард Хятадын таван төр өөр хоорондоо дайн дажинг хийж, тус тусын аж ахуй, эдийн засгийг ихэд сүйрүүлж байв. Өмнөд Хятадын арван улс хоорондоо дайтах нь арай бага байсан, умард хятадаас олон хүн Өмнөд Хятадад энхийг эрж зугтан очсон зэрэг шалтгааны учир Өмнөд Хятадын аж ахуй, эдийн засаг, соёлын хөгжилд мэдэгдэхүйц ахиц гарчээ.

Тэр хооронд Цагаан хэрмийн хойгуур Ляохэ хэмээх Зүүн Шар мөрөн, Халуун голын орчим нутаглаж байсан сяньбийн угсааны монгол хэлтэн Киданы найман аймаг нэгдэж, 916 онд феодалжигч сурвалжтан Елюй Амбагай хаан тэргүүтэй нүүдэлчдийн нэлээд хүчирхэг төр улсыг байгуулсан нь Умард Хятадын цаашдын амьдрал, хөгжилд ноцтой нөлөө үзүүлсэн юм. Кидан улс Бээжин, Тайюань зэрэг умард хятадын зарим нутгийг байлдан эзэлж, 937 онд Бээжинд төвлөсөн Ляо гүрэн хэмээх шинэ эзэнт улсыг байгуулжээ.

960 онд Умард Хятадын хожуу Чжоу улсын хаан Чжао Куанинь Умард, Өмнөд Хятадын зарим газар нутгийг нэгтгэн захирч түүхэнд ихээхэн нэрд гарсан Хятадын Сүн улсыг байгуулжээ. Сүн улс идэвхтэй бодлого явуулж, Ляо улсын захиргаанд ороогүй үлдсэн умард Хятадын бусад төр улсууд болон Өмнөд Хятадын арван улсыг нэгтгэн захирч бас нэг томоохон эзэнт гүрэн болсон байна.

1115 онд Манжуур нутагт Агуда тэргүүтэй түнгүс, манж угсааны нүүдэлчдийн Зүрчид улс байгуулагдаж, 1125 оны үест Ляо улсыг Сүн улсын тусламжтайгаар мөхөөжээ. Түүхэнд Зүрчидийн Алтан улс гэж алдаршсан тэр улс нь удалгүй Сүн улсын мэдэлд байсан Хөх мөрнөөс хойших Умард Хятадын бүх газар нутгийг булаан эзлээд улмаар Өмнөд Хятадын Сүн улсын эсрэг түрэмгий дайн эхэлсэн байна. Алтан улсын түрэмгийллийн эсрэг тэмцэлд Сүн улсаас Йо Фей нарын зэрэг эх оронч баатрууд төрөн гарч байсан боловч урвагч хятад ноёд тэд-

нийг хорлон алж, тэмцлийн эрч хүчийг сулруулсан учир Сүн улс давшин байлдах чадварыг алдаж, зөвхөн хориглон хамгаалах арга хэмжээ авах төдийгөөр үйл ажиллагаагаа хязгаарлахад хүрч байжээ.

Умард Хятад дахь Зүрчидийн Алтан улс нь Монголын эсрэг ихээхэн түрэмгий бодлого явуулж байсан юм. Гэвч 1206 онд Чингис хаан тэргүүтэй Монголын феодалын нэгдсэн улс байгуулагдаад Алтан улсын эсрэг хариу довтолгоон хийж, 1215 онд түүний нийслэл Бээжин хотын зэрэг газруудыг эзлэн авсан байна. Монгол улсын тэргүүн (ерөнхий) сайд Мухулай нар дахин их цэрэг хөдөлгөж Алтан Улсын эсрэг байлдахад Сүн улс түүнд тусалсан юм. Монголын цэрэг 1234 онд Алтан улсыг бүрмөсөн мөхөөж, умард Хятадыг эзлэн авчээ.

Түүний дараа 1260--1279 оны хооронд Чингисийн ач хүүгүүн Хубилай хаан Сүн улсыг байлдан эзэлж, бүх Хятадыг эрхшээлдээ оруулан Юан гүрнийг байгуулсан байна. Юан улс Бээжинд төвлөн нийслэлж байсан боловч Хятадын угсааны төр биш, харин түүнийг үгүйсгэн устгасан харь орны байлдан дагуулагчдын ноёрхлын улс төрийн гол аппарат байсан юм. Тийм учраас Юан улсын төр, түүнийг үндэслэн байгуулагч Хубилайг зарим хятад түүхчдийн бичиж, ярьж байгаатай адил хятадын угсааны төрүүд болон хятадын төрийн зүтгэлтнүүдийн эгнээнд оруулан дансалж үл болно. Тэгэх тусмаа Юан улс байгуулагдахаас 40-өөд жилийн өмнө нас барчихаад байсан Чингисээр Юан улсыг «үндэслэн байгуулагч», «хятадын» төрийн зүтгэлтэн болгож дүрслэх ямар ч үндэс үгүйсэн билээ.

Хятадын ард түмэн Монголын феодалуудын байгуулсан Юан улсын ноёрхлыг харийн булаан эзлэгчдийн харгис талхидал гэж үзэн ядаад зэвсэглэн босч тэмцсээр байв. 1368 онд Чжү Юаньчжан тэргүүтэй тариачдын бослогын цэрэг Юан улсын ноёрхлыг эцэс болгож, түүний үр дүнд Хятадын Мин улс байгуулагдсан байна. Мин улс нь Хятадын Нэгдмэл байдал, төр улсыг сэргээн эх орны эдийн засаг, соёлыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.⁴ Мин улсын хаад Монголын эсрэг түрэмгий бодлого явуулж байсан боловч түүнийгээ хэрэгжүүлж чадаагүй юм. Мин улс нь XVII зууны эхээр Монголтой зарим талаар зохицон манжийн түрэмгийллийг урьдчилан сэргийлж, хориглон хамгаалах бодлого явуулахыг оролдож байв.

Хөгжингүй феодализмын үеийн хятадын угсааны төрүүд эргэн тойрны улс орны хувьд, ялангуяа Монгол улсын эсрэг жанжлан түрэмгийлэх бодлого явуулж, Монгол зэрэг Төв Азийн нүүдэлчин улс аймгийн хаад ноёд ч гэсэн Хятадыг түрэмгийлэн эзлэх бодлого сэргүүлэн тавьж, түүнийгээ зарим үед бүрэн буюу хагас аливаа байдлаар хэрэгжүүлж байсан ч гэсэн Хятад орны үйлдвэрлэх хүчин, эдийн засаг, соёлын амьдралд мэдэгдэхүйц ахиц гарч байсан байна.

Таван төр, арван улсын үед Хөх мөрөн, Хуай голын сав газарт далан барьж, суваг шуудуу татан, хиймэл нуур байгуулж, Өмнөд Хятадад тариалангийн ажлыг нэлээд өөд татан урагшлуулсан байна. Сүн улсын үед төмөр ба мөнгөний уурхай нэлээдийг шинээр нээн ажиллуулж, алтан, мөнгөн, хүрэл зоос цутгах, архи дарс нэрэх газарт хөлсний ажилчид ажиллуулах болж байжээ. Дотоод, гадаад худалдаа хөгжиж, банк нээх, цаасан мөнгө үйлдэж хэрэглэх болж байв. Тухайн үед үр тарианы ба мөнгөн зээлийн хүү нь 2--3 зуун хувь болж байсан учир эрдэмтэн түшмэл Ван Аньши (XI зуун) шинэтгэл хийж, зээлийн хүүг 20 хувиар хязгаарлах зэрэг шийдвэртэй арга хэмжээ авах

⁴ Джавхарал Неру. Взгляд на всемирную историю, т. 2. М., 1981. С: 10—11.

гэсэн боловч тэр нь бүтсэнгүй. Цэргийн албыг гол төлөв хөлсний цэргээр хаалгаж байсныг өөрчилж, ард нийтийн дундаас журмын цэрэг татахыг оролдож байв. IX зууны үед дарь их хэмжээгээр үйлдвэрлэн, XI зууны үеэс эхлэн цэрэг дайны ажиллагаанд хэрэглэх болж байв. Юан гүрний үед Өмнөд Хятадын Шанхай, Кантон зэрэг далайн боомтуудыг өргөтгөж, Хөх мөрнөөс Бээжин хүртэл татсан хуучин их сувгийг сэлбүүлэн засаж, усан замын тээврийг өөд татсан боловч тэр нь гол төлөв хөдөө нутгаас хураасан тариа будааг төв өөд зөөвөрлөхөд зориулагдаж байв. Монгол хаад улсын сан хөмрөгийг зузаатгах, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор удаа дараалан их хэмжээний цаасан мөнгө үйлдүүлэн гаргаж байсан нь мөнгөний ханшийг 50-иад жилийн дотор 25 дахин бууруулж, юмны үнийг нэмэгдүүлэн ард түмний аж байдлыг ихэд доройтуулсан байна. Мин улсын үеийн Хятадад Бээжин, Нанжин зэрэг 35 томоохон хот ихэд хөгжиж, гар урлал, худалдааны чухал төв болсон байна. Хамгийн сонин бөгөөд чухал зүйлийн нэг бол Мин улсын дотор XVI зууны үеэс эхлэн улсын ба хувийн мануфактур үүсэн дэлгэрч байсан явдал юм. Тэдгээр мануфактурын дундаас улсын мануфактур нь ихэвчлэн хамжлагын ажилчдын хүч хөдөлмөрт тулгуурлаж байсан бол гол төлөв нэхмэлийн үйлдвэрлэл дээр байгуулагдсан хувийн мануфактур нь хөлсний ажилчдын хүч хөдөлмөр хэрэглэж, капиталист маягийн мануфактур болж байжээ. Тийнхүү XVI--XVII зууны Хятадын нийгэмд капитализмын үр хөрөнгө үүсэн бүрэлдэж байсан байна.⁵ Мөн XVI зууны үеэс эхлэн Хятадад Баруун Европын хөрөнгөтөн орнуудын колоничлогчид, худалдаачид, католик шашин номлогчид хүчтэй нэвтрэн орох болсон байна. 1516 онд португаличууд Кантонд орж сууршаад 1557 онд Макао түрээслэн авчээ. 1620-иод оны үест голландчууд Макао, Амойд, 1524 онд Тайваньд нэвтрэн орсон байна. 1657 онд англичууд бас Кантонд нэвтрэн орж сууршмал худалдаа хийх зэргээр колоничлолын бодлогыг хэрэгжүүлж эхлэн байв. Баруун Европын католик шашин номлогчид нь тус тусын орны засгийн газрын захиас даалгавраар Хятадын улс төр, газар зүй, эдийн засаг, цэрэг дайны ба соёлын холбогдолтой мэдээ баримт цуглуулж, ялангуяа XVII зууны үеэс эхлэн өрнөдийн колоничлолын бодлогод ихээхэн идэвхитэй үйлчлэх болж байв.

XVII зууны 30—40-өөд оны үест Хятадын Мин улсын дотор ангийн тэмцэл хурцдаж, Лн Цзычэн тэргүүтэй тариачны бослого гараад нийслэл Бээжин хотыг эзэлсэнд Мин улсын хаан амиа хорлож үхсэн байна. Тариачны бослогын ялалтаас айж болгоомжилсон Мин улсын зүүн хойт хилийн цэргийн жанжин нар нь түүнтэй түүнгүй Хятадад заналхийлж байсан Манжийн цэрэгт 1644 оны үеэр Цагаан хэрмийн боомтын хаалгыг дэлгэн өгч, дотогш оруулаад түүнтэй хүч хавсран бослогыг даржээ. Гэтэл манжийн цэрэг зөвхөн тариачны бослогыг дараад зогссонгүй, Мин улсын нийслэл болон бусад нутгийг байлдан эзэлж Хятад даяар ноёрхлоо тогтоосон байна. Баруун Европод анхны хөрөнгөтний хувьсгалууд ялж, капитализмд шилжин орох шинэ үе эхлээд байхад Хятад орон тийнхүү нүүдлийн цэрэг-феодалын харь манжийн ноёрхолд автсан байна.

Манж нар анхнаасаа Монгол, Хятад, Солонгосын эсрэг түрэмгий бодлого явуулж, 1634 онд Өвөр Монголыг, 1691 онд Ар Монголыг, 1723 онд Хөх нуурын Монголыг, 1755--1758 оны үест Баруун Мон-

⁵ Бай Шоуи, Хятадын ерөнхий түүхийн хураангуй. Бээжин 1980, 356, 363—366-р тал. (хятадаар)

голын Зүүнгарын хаант улс, дорнод Туркестаныг байлдан эзэлж, Манж Чин улсын захиргаанд оруулсан байна. Манжийн хаад бас XVIII зууны дундуур Төвдөд цэргээ оруулж дарангуйлан, Солонгос, Вьетнам зэрэг улс орныг түшмэг хараат улсын байдалтай болгох гэж оролдож байв.

XIX зууны дунд үеэс эхлэн Англи зэрэг Баруун Европын хөрөнгөтөн орнууд Манж Чин улсад цэрэг зэвсгийн хүчээр довтолж, эрх тэгш биш гэрээ хэлэлцээр тулган хүлээлгэж, Хятадын зах зээлд янз бүрээр нэвтэрч, шигдэн орох болжээ. XIX зууны эцэс—XX зууны эхээр Япон, Америк, Европын империалист улс гүрнүүд Хятадыг тус тусын «нөлөөний хүрээ»-нд хэсэгчлэн оруулж, тал тал тийш тасчин хуваах замд ороод өөр хоорондоо өрсөлдөж байв.

Манжийн ноёрхлын үе бол Хятад зэрэг эзлэгдсэн орнуудын хувьд хожуу феодализмын шатыг туулан өнгөрүүлж байсан үе байв. Манжийн ноёрхол, империалист гүрнүүдийн колоничлолын бодлого зэрэг нь Хятадын эдийн засаг, соёлын эрчимтэй хөгжих явдлыг саатуулж байсан боловч Мин улсын үеэс уламжлан ирсэн капитализмын үр хөврөл цаашид аажмаар дэлгэрэн хөгжихийг бүрмөсөн хааж чадахгүй байв. Европ, Америк, Японы аж үйлдвэрийн капитализм, худалдаа-санхүүгийн нөлөө Хятадад тусахгүй байж болохгүй байв. Хятадад нэгэн талаас өөрийн орны зах зээлийг гадаадын капиталтай холбон жуулчилдаг худалдааны жууч либерал хөрөнгөтөн, нөгөө талаас капиталист аж үйлдвэрийн эх үүсвэрийг тавьж байсан үндэсний хөрөнгөтөн, жич бас ажилчин анги бий болж, улс нийгмийг тухайн үеийнхээ олон улсын хөгжлийн түвшинд эгнэтэл их, бага аливаа хэмжээгээр шинэчлэн хөгжүүлэхийг шаардаж байв. Эцсийн эцэст манжийн хаан Бадаргуулт төр, Чин улсын засгийн газар ч гэсэн шинэ үеийн шаардлага, өөрийн ноёрхлыг бэхжүүлэн хадгалж үлдээх зорилтын үүднээс хүч нөлөө бүхий томоохон сайд Ли Хүнчжанаар удирдуулан улсын зэр зэвсгийн завод барих зэргээр улсын капитализмын шинжтэй зарим зүйлийг хөгжүүлж, Ван Юэй тэргүүтэй либерал хөрөнгөтний шинэтгэлийн бодлогын нөлөө бүхий «шинэ засгийн бодлого» гэгчийг тунхаглахад хүрсэн байна. Гэвч тэр нь Монгол зэрэг эзлэгдсэн орнуудыг хятад тариачид, цэргээр дүүргэн, хятадын жирийн нэг муж хязгаар болгож бүрмөсөн колоничлоход чиглэгдсэн залихай явуулга байв.

Манжийн ноёрхол, хөрөнгөтөн гүрнүүдийн түрэмгийлэл, империализмын колоничлолын бодлогыг Чин улсын захиргаанд байсан хятад, монгол, төвд зэрэг улс түмнүүд ямагт идэвхтэй эсэргүүцэн тэмцэж байв. XVII зууны дунд үеэр Хятад, Өвөр Монгол XVIII зууны дундуур Халх, Баруун Монгол, Төвд, XIX зууны дунд үе, дэд хагаст Хятад,⁶ Синьцзяны (урьдын Дорнод Туркестан, Зүүнгарын хаант улсын зарим нутгийн) ард түмэн манжийн ноёрхлын эсрэг, тус тусын орны тусгаар тогтнолыг сэргээн мандуулахын төлөө босч тэмцэж байв. 1900—1901 оны үест Хятадын ард түмэн империалист гүрнүүдийн түрэмгийллийг эсэргүүцэн босч тэмцсэн нь түүхэнд Ихэтуаний бослого гэж алдаршсан юм. Тэр бослогыг империалист найман гүрний цэрэг цуслан дарж, Хятад орон нийт Манж Чин улсыг хагас колонийн орон болгосон байна. Манж Чин улсын засгийн газар нь тэр цагаас хойш зөвхөн өөрөө хятад, монгол, төвд, хотон, манж угсааны ард олныг ноёлон дарлаад

⁶ Тайпины бослого. Хятадын орчин үеийн түүх. Бээжин, 1979, 51-р тал. (хятадаар)

зогсохгүй, мөн өөрөө империалист гүрнүүдийн дуулгавартай зарцын байдалд орж, тэдний зүгээс тус орныг колончлон мөлжих явдлыг шууд зөвшөөрөн дэмжих болсон байна.

Манжийн хаад, чанкайшийнхан болон маогийнхны жанжлах бодлогын уламжлал дагуу хятадын зарим түүхчид БНХАУ-ын дэвсгэр нутгийн цар хүрээг Манж Чин улсын нутгийн хэмжээгээр бодож тэлэх зорилтыг түүхийн үүднээс үндэслэн нотлохыг оролдож байна. Гэтэл Манжийн ноёрхолд байсан Монгол, Төвд, Манж, Хотон зэрэг нь Хятадын нэгэн адилаар Чин улсын бүрэлдүүнд хүчээр түр нэгтгэгдэн захирагдаж байсан тус тусдаа өөр утсаатан байсан болохоос биш, хэзээ ч «хятадын хэсэг», тэгэх тусмаа «салшгүй хэсэг» нь болж байгаагүй юм. Манжийн ноёрхлын үед Хятад нь Чин улсын ноёрхлыг устган чөлөөлөгдөх, монгол, төвд, хотон нь манж, хятадаас тусгаарлан салахыг зорьж янз бүрээр эсэргүүцэн тэмцэж байв. 1900 онд Халхын ноёд оросын засгийн газарт тусгай төлөөлөгчдийг илгээж, Манж Хятадаас тусгаарлан салахад тусламж дэмжлэг үзүүлэхийг хүсч байжээ. Тэр цагаас хойш Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцэл улам улмаар идэвхижин үргэлжилж байв. Өвөр Монгол, Хөх нуур, Синьцзяны монголчууд, Төвд, Дорнод Туркестанд ч гэсэн Манж Чин улсаас тусгаарлан салах зорилготой хөдөлгөөн тэмцэл удаа дараалан өрнөж байв. Гэвч Чин улсын захиргаан дахь дан ганц хятад юм уу эсхүл бусад угсаатан ястны ганц ганцаар уван цуван гаргасан тусгаар тогтнолын тэмцэл манжийн ноёрхлоос чөлөөлөгдөх зорилтыг хэрэгжүүлж чадахгүй байв.

Гагцхүү 1911 онд Хятадад империализмын колоничлол, манжийн ноёрхол, хаант ёс, феодалын дэглэмийн эсрэг хятадын ардчилсан хувьсгалч доктор Сүн Ятсений удирдан зохион байгуулсан хөрөнгөтний хувьсгал гарч, түүнтэй хамт Монгол, Төвд зэрэг оронд үндэсний эрх чөлөөний тэмцэл нэгэн зэрэг өрнөсний ачаар Манжийн ноёрхол эцэс болж, хөрөнгөтний бүгд найрамдах засаг Хятадад тогтоод Ар Монгол тусгаар тогтнолоо тунхаглан зарлаж, үндэсний төр улсыг сэргээн байгуулсан байна.

Гэвч гагцхүү Октябрийн социалист их хувьсгалын дараах нэн шинэ үеийн нөхцөлд 1921 оны Монгол ардын хувьсгал мандаж, дэлхийн анхны социалист гүрний тусламж дэмжлэгийг олсноор Монгол орон, Монгол улс, Монголын ард түмэн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа жинхэнэ ёсоор сэргээн мандуулж, Лениний заасан капиталист биш замаар замнан эх орондоо социализм байгуулж цэцэглэн хөгжих зорилтыг хэрэгжүүлж чадсан юм.

КИТАЙСКОЕ ФЕОДАЛЬНОЕ ГОСУДАРСТВО (III в.--1911 г.)

(Р е з ю м е)

В данной статье автор, вкратце излагая основные моменты политической истории феодального Китая, дает обзорно-обобщающую характеристику процессам становления, развития и упадка феодализма в стране.

Автор, подчеркивая мысль о том, что сущность и характер феодализма в Китае в основном были общими с главными чертами феодального развития других стран, в то же время не отрицает наличия у китайского феодализма ряда таких особенностей как: формирование его на материальной базе и в духовной сфере, унаследованных от рабовладельческого прошлого, существование верховной государственной собственности на землю наряду с частными феодальными земельными владениями, главенствующая роль в идеологической области этико-политического, не совсем религиозного, конфуцианского учения.

Согласно мнению автора, Китай вступил на путь феодального развития в III в., т.е. со времени троецарствия, а полное утверждение феодализма относится к последним периодам правления танской династии, к IX и началу X вв. С приходом к власти Сунской династии в начале X в. Китай встал на стадии расцвета феодализма, которая завершается в конце минского периода (XVII в.). Когда Западная Европа уже встала на капиталистический путь развития в XVII в. и начался новый период истории человечества, Китай подпал под власть кочевого, маньчжурского военно-феодального государства. Цинский период, продолжавшийся до начала XX в., являясь тяжелым периодом для Китая, содействовал превращению страны в полуколонию империализма, тяжело отразился на положение китайских трудящихся, на перспективы социально-экономического и культурного развития народов, подвластных маньчжурам. К тому же на рубеже XIX—XX вв. маньчжурский двор преследовал цель «Самоусиления» цинской империи путем проведения «нового курса политики», означавшего для Китая лишь ряда половинчатых буржуазно-помещичьих либеральных реформ, которые приносили монголам и другим неханьским народам угрозу немедленной внутренней колонизации в духе форсированного китаизирования. Изолированные выступления китайцев, монголов, тибетцев и других народов, все виды борьбы за национальное и социальное освобождение в отдельности против маньчжуров и иностранных колонизаторов не привели к ощутимым результатам.

Тем не менее в глубине китайского общества, начиная уже с минского периода, зарождались элементы новых производительных сил и производственных отношений капиталистического типа, которые во времена цинского господства вопреки всем его препятствиям постепенно развивались и укреплялись, получив дополнительный импульс с созданием немногих заводов и фабрик, строительством железных дорог и другими проникновениями капитализма. В Китае возникали либерально-компрадорская и национальная буржуазия, рабочий класс, буржуазного типа интеллигенция. В начале XX в. Китай оказался перед необходимостью буржуазно-демократических преобразований, не говоря уже о давно начавшемся национально-освободительном движении китайцев, монголов, тибетцев и других народов.

На основе всего этого в Китае назрела буржуазная революция 1911 г., которая свергнула двухвековое господство маньчжуров и привела страну к буржуазно-помещичьему республиканскому строю. К тому времени в Монголии и Тибете развернулась мощная национально-освободительная борьба, в результате которой согласно стремлениям и чаяниям монгольского народа было объявлено о восстановлении независимости страны.

Однако, лишь победа антиимпериалистической, антифеодальной революции монгольского народа 1921 г., совершившейся в новых меж-

дународных условиях послеоктябрьского периода, принесла монгольскому народу политическую независимость, подлинную возможность суверенного развития страны по некапиталистическому пути, указанному Лениным, и построения нового, социалистического общества.

В статье подвергается сомнению и критикуется маоистская концепция о том, будто Китай издревле являлся «многонациональным государством», которое представляет некую «единую, неделимую, все охватывающую Китайскую государственную нацию» (чжунхуа миньцзу).

Автор подвергает критике такого рода гегемонистские извращения китайскими историками истории Китая, да и других стран, обосновывает, наоборот, ту мысль, что Китай лишь в новое и новейшее время постепенно превратился в многонациональное государство. В статье отмечается необходимость марксистско-ленинского подхода к изучению истории Китая, критического анализа публикуемых в КНР материалов и работ по истории этой страны.